



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН МАЛЫН УДМЫН САНГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/118/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор Ч.Гантулга

Утас: 70373089 Цахим хаяг: gantulgachu@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2025 он

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Төлбөрийн акт	20
5.2 Албан шаардлага	20
5.3 Зөвлөмж	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн яам
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТҮ	Төрийн үйлчилгээ
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МАЛЫН УДМЫН САНГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ч.ГАНТӨГС ТАНАА

2025.02.25 № 59

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Малын удмын сангийн үндэсний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн сахилгын шийтгэлийн хугацаа дуусаагүй албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон, ээлжийн амралтын цалинг илүү тооцож олгосон, авлага, өглөгийн үлдэгдэл дүнг тооцоо нийлж баталгаажуулаагүй, нэг төрлийн ажил үйлчилгээг жижиглэн шууд гэрээ байгуулсан, худалдан авах ажиллагааны үр дүнг цахим сайтад байршуулаагүй зөрчлүүд нь бидний тогтоосон 277,885.9 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 48 дугаар зүйлийн 48.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "Оршин байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

4525020195

Асуудлыг онцолсон хэсэг

Тус төвд ХХААХҮЯ-аас малын чанар үйлдвэрийг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор 262,037.5 мянган төгрөгийн үнэ бүхий өндөр ашиг шимт бухын гүн хөлдөөсөн 8,750 тун үр, үйлдвэрлэлээр 9,441 литр шингэн азот үйлдвэрлэж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар үйлдвэр, захиргааны байрыг 263,831.8 мянган төгрөгөөр засварласныг санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосноор цалингийн зардал 125,826.2 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 15 хувиар өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Малыг удмын сангийн үндэсний төв 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 13 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 78 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР




2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,437,751,221.47	12,491,100,383.20
33	АВЛАГА	935,082,288.36	981,071,797.95
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	37,752,101.30	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	4,000,000.00	-
33500	Бусад авлага	893,320,187.00	981,071,797.95
33510	Байгууллагаас авах авлага	522,789,303.37	517,790,278.67
33520	Хувь хүмүүсээс авах авлага	370,530,883.63	426,875,873.08
33530	Ажилчдаас авах авлага	36,405,646.20	36,405,646.20
34	УРЬДЧИЛГАА	70,860,000.00	70,860,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	70,860,000.00	70,860,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	11,431,808,933.11	11,439,115,585.25
35100	Түүхий эд материал	198,248,066.31	177,843,005.31
35110	Тусгай зориулалтын материал	184,292,966.31	173,516,805.31
35130	Эм боох материал	13,955,100.00	4,326,200.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	801,081,030.99	859,869,454.80
35400	Хангамжийн материал	92,661,615.00	144,312,557.11
35410	Бичиг хэргийн материал	311,000.00	2,349,000.00
35420	Аж ахуйн материал	45,601,000.00	99,674,636.00
35430	Сэлбэг хэрэгсэл	7,750,000.00	11,077,600.00
35440	Түлш, шатах тослох материал	4,273,925.00	1,096,741.11
35460	Хүнсний материал	211,500.00	336,000.00
35470	Бусад хангамжийн материал	34,514,190.00	29,778,580.00
35600	Мал амьтад	10,339,818,220.81	10,257,090,568.03
36	НӨӨЦИЙН БАРАА	-	1,053,000.00
36300	Тэжээлийн нөөц	-	1,053,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,664,685,529.89	15,274,163,862.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,664,685,529.89	15,274,163,862.89
392	Биет хөрөнгө	14,890,658,396.50	14,500,836,729.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	14,483,559,221.69	14,747,391,003.34
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,726,080,473.28)	(3,204,900,953.16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	314,772,054.60	314,772,054.60
39204	Хуримтлагдсан элэгдэл	(230,156,306.76)	(247,614,591.24)
39205	Машин тоног төхөөрөмж	3,846,335,448.15	3,930,797,418.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,344,169,698.73)	(1,433,062,171.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	537,209,282.64	537,209,282.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	(376,892,421.46)	(429,253,924.19)
39214	Бусад үндсэн хөрөнгө	591,219,754.00	591,219,754.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(235,380,108.75)	(335,962,787.66)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	30,241,644.40	30,241,644.40
39300	Биет бус хөрөнгө	774,027,133.39	773,327,133.43
39301	Програм хангамж	7,626,000.00	7,626,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,892,666.61)	(6,592,666.67)

39303	Бусад биет бус хөрөнгө	772,293,800.00	772,293,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	28,102,436,751.36	27,766,264,246.09
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	117,946,020.17	121,151,072.85
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	117,946,020.17	121,151,072.85
413	Өглөг	117,946,020.17	121,151,072.85
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	3,425,075.44
41312	НДШ-ийн өглөг	-	781,818.19
41313	ХАОАТ-ын өглөг	-	2,643,257.25
41350	Зээлийн хүүгийн өглөг	6,684,115.38	6,684,115.38
41360	Бусад өглөг	111,261,904.79	111,041,882.03
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	27,984,490,731.19	27,645,113,173.24
51	Засгийн газрын хувь оролцоо	27,984,490,731.19	27,645,113,173.24
511	Засгийн газрын оруулсан капитал	1,496,570,935.15	1,496,570,935.15
51101	Өмч: - төрийн	1,496,570,935.15	1,496,570,935.15
512	Хуримтлагдсан үр дүн	25,916,709,213.32	25,577,331,655.37
51210	Өмнөх үеийн үр дүн	24,265,449,943.73	25,953,452,013.32
51220	Тайлант үеийн үр дүн	1,651,259,269.59	(376,120,357.95)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	571,210,582.72	571,210,582.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	28,102,436,751.36	27,766,264,246.09



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,732,263,825.78	3,113,351,102.53
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,294,356,725.78	1,165,397,602.53
120	Нийтлэг татварын бус орлого	3,294,356,725.78	1,165,397,602.53
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	201,509,299.52	302,037,473.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	144,846,571.32	192,955,550.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	36,261,628.20	103,146,923.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,092,847,426.26	863,360,129.04
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,437,907,100.00	1,947,953,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,428,363,100.00	1,937,003,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,428,363,100.00	1,937,003,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,544,000.00	10,950,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,544,000.00	10,950,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,954,295,650.51	3,486,471,460.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,954,295,650.51	3,486,471,460.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,912,533,226.51	3,475,691,335.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	619,978,928.65	947,873,795.34
210101	Үндсэн цалин	400,232,387.64	506,667,801.42
210102	Нэмэгдэл	110,965,176.81	284,960,293.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	88,108,000.00	129,996,000.00
210104	Урамшуулал	20,673,364.20	26,249,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,940,878.29	123,174,210.32
210201	Тэтгэврийн даатгал	54,740,159.82	82,887,006.26
210202	Тэтгэмжийн даатгал	6,440,018.97	9,692,588.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,993,615.11	9,016,642.46
210204	Ажилгүйдлийн даатгал	1,137,263.98	4,315,594.50
210205	Эрүүл мэндийн даатгал	11,629,820.41	17,262,378.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	130,771,955.68	91,435,219.99
210301	Гэрэл, цахилгаан	34,226,276.68	40,126,163.99
210302	Түлш, халаалт	87,378,572.00	45,800,000.00
210303	Цэвэр, бохир ус	5,207,107.00	5,509,056.00
210304	Байрны түрээс	3,960,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	185,254,187.20	133,555,118.98
210401	Бичиг хэрэг	9,041,612.00	4,885,500.00
210402	Тээвэр, шатахуун	38,322,144.90	39,495,061.83
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,896,000.00	3,586,089.37
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	528,489.94	14,384,690.00
210408	Бараа материал акталсны зардал	135,465,940.36	71,203,777.78
2105	Нормативт зардал	37,646,150.06	30,842,996.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,453,410.00	20,163,996.00
210502	Хоол, хүнс	14,192,740.06	10,679,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,189,300.00	27,753,536.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	250,000.00	-
210604	Урсгал засвар	13,939,300.00	27,753,536.00
2107	Томилолт, зочны зардал	8,749,248.00	53,362,262.00
210702	Дотоод албан томилолт	8,749,248.00	53,362,262.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	510,087,213.87	534,603,791.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	503,262,910.87	515,846,177.57
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,499,800.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	124,503.00	841,054.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	80,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,200,000.00	8,080,000.00
210807	Газрын төлбөр	-	9,756,560.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,326,915,364.76	1,533,090,405.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	586,565,399.67	800,846,092.26
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	740,349,965.09	732,244,313.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,762,424.00	10,780,124.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,986,869.00	2,670,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,510,789.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,476,080.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,670,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,775,555.00	8,110,124.93
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,775,555.00	8,110,124.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,777,968,175.27	(373,615,338.95)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	126,708,905.68	3,000,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	126,708,905.68	3,000,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(126,708,905.68)	(3,000,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,651,259,269.59	(376,120,357.95)




2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,764,232,975.00	2,187,710,970.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	326,325,875.00	239,757,470.00
120	Нийтлэг татварын бус орлого	326,325,875.00	239,757,470.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	326,325,875.00	239,757,470.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	126,882,225.00	52,361,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	199,443,650.00	187,396,370.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,437,907,100.00	1,947,953,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,428,363,100.00	1,937,003,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,428,363,100.00	1,937,003,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,544,000.00	10,950,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,544,000.00	10,950,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,764,232,975.00	2,187,710,970.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,764,232,975.00	2,187,710,970.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,718,470,551.00	2,176,930,845.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	617,840,088.41	945,805,175.06
210101	Үндсэн цалин	407,439,814.14	504,970,031.94
210102	Нэмэгдэл	110,646,324.50	283,920,434.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	81,517,793.25	130,243,808.94
210104	Урамшуулал	18,236,156.52	26,670,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,158,603.99	123,351,800.00
210201	Тэтгэврийн даатгал	58,604,403.99	89,394,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,888,500.00	8,489,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,710,900.00	4,244,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,177,700.00	4,244,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,777,100.00	16,978,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	181,917,502.29	185,830,708.59
210301	Гэрэл, цахилгаан	34,226,276.68	40,126,163.99
210302	Түлш, халаалт	131,514,701.61	140,195,488.60
210303	Цэвэр, бохир ус	8,256,524.00	5,509,056.00
210304	Байрны түрээс	7,920,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	18,384,000.00	43,262,739.37
210401	Бичиг хэрэг	1,147,900.00	5,898,700.00
210402	Тээвэр, шатахуун	10,767,500.00	30,877,740.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,896,000.00	3,586,089.37
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,572,600.00	2,900,210.00
2105	Нормативт зардал	300,000.00	9,520,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	9,520,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,565,900.00	43,630,360.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,153,000.00	3,360,000.00



210604	Урсгал засвар	33,412,900.00	40,270,360.00
2107	Томилолт, зочны зардал	8,880,548.00	51,262,262.00
210702	Дотоод албан томилолт	8,880,548.00	51,262,262.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	770,887,408.31	761,798,500.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	764,063,105.31	743,040,886.57
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,499,800.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	124,503.00	841,054.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	80,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,200,000.00	8,080,000.00
210807	Газрын төлбөр	-	9,756,560.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,536,500.00	12,469,299.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,536,500.00	12,469,299.48
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,762,424.00	10,780,124.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,986,869.00	2,670,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,510,789.00	-
213207	Тэтгэвэрт гарах олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,476,080.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,670,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,775,555.00	8,110,124.93
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,775,555.00	8,110,124.93
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний ноёц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,496,570,935.15	587,613,460.28	24,248,207,482.92	-	26,332,391,878.35
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	17,242,460.81	-	17,242,460.81
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,496,570,935.15	587,613,460.28	24,265,449,943.73	-	26,349,634,339.16
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(16,402,877.56)	-	-	(16,402,877.56)
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	1,651,259,269.59	-	1,651,259,269.59
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,496,570,935.15	571,210,582.72	25,916,709,213.32	-	27,984,490,731.19
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,496,570,935.15	571,210,582.72	25,916,709,213.32	-	27,984,490,731.19
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	36,742,800.00	-	36,742,800.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,496,570,935.15	571,210,582.72	25,953,452,013.32	-	28,021,233,531.19
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(376,120,357.95)	-	(376,120,357.95)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,496,570,935.15	571,210,582.72	25,577,331,655.37	-	27,645,113,173.24




2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,210,896,300.00	2,168,650,845.07	(42,245,454.93)	98.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,10,896,300.00	2,168,650,845.07	(42,245,454.93)	98.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,206,275,300.00	2,165,980,845.07	(40,294,454.93)	98.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	977,124,100.00	945,805,175.06	(31,318,924.94)	96.8
210101	Үндсэн цалин	611,415,600.00	504,970,031.94	(106,445,568.1)	82.6
210102	Нэмэгдэл	253,410,800.00	283,920,434.18	30,509,634.18	112.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	88,054,600.00	130,243,808.94	42,189,208.94	147.9
210104	Урамшуулал	24,243,100.00	26,670,900.00	2,427,800.00	110.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	123,351,800.00	123,351,800.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	89,394,200.00	89,394,200.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	8,489,400.00	8,489,400.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,244,700.00	4,244,700.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,244,700.00	4,244,700.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	16,978,800.00	16,978,800.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	189,172,100.00	185,830,708.59	(3,341,391)	98.2
210301	Гэрэл, цахилгаан	41,710,900.00	40,126,163.99	(1,584,736)	96.2
210302	Түлш, халаалт	113,962,600.00	140,195,488.60	26,232,888.60	123.0
210303	Цэвэр, бохир ус	33,498,600.00	5,509,056.00	(27,989,544)	16.4
2104	Хангамж, бараа материалын зардал	44,084,600.00	43,262,739.37	(2,052,006.3)	95.3
210401	Бичиг хэрэг	5,910,700.00	5,898,700.00	(573,400.00)	91.1
210402	Тээвэр, шатахуун	30,877,900.00	30,877,740.00	1,792,240.00	106.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,610,000.00	3,586,089.37	(2,023,911.00)	63.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,917,000.00	2,900,210.00	(16,790.00)	99.4
2105	Нормативт зардал	9,712,100.00	9,520,000.00	(192,100.00)	98.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,712,100.00	9,520,000.00	(192,100.00)	98.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	45,076,900.00	43,630,360.00	(1,446,540.00)	96.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,797,900.00	3,360,000.00	(1,437,900.00)	70.0
210602	Тавилга	4,000,000.00	-	(4,000,000.00)	-
210604	Урсгал засвар	36,279,000.00	40,270,360.00	3,991,360.00	111.0
2107	Томилолт, зочны зардал	51,271,200.00	51,262,262.00	(8,938.00)	100.0
210702	Дотоод албан томилолт	51,271,200.00	51,262,262.00	(8,938.00)	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	754,013,200.00	750,848,500.57	(3,164,699.43)	99.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	732,469,200.00	732,090,886.57	(378,313)	99.9
210803	Даатгалын үйлчилгээ	74,900.00	-	(74,900)	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,648,100.00	841,054.00	(1,807,046)	31.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	80,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,088,000.00	8,080,000.00	(8,000)	99.9
210807	Газрын төлбөр	10,653,000.00	9,756,560.00	(896,440)	91.6



2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,469,300.00	12,469,299.48	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,469,300.00	12,469,299.48	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,390,000.00	2,670,000.00	(720,000.00)	78.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,390,000.00	2,670,000.00	(720,000.00)	78.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,390,000.00	2,670,000.00	(720,000.00)	78.8
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,210,896,300.00	2,168,650,845.07	(42,245,454.93)	98.5
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,937,003,500.00	1,928,893,375.07	(8,110,124.93)	99.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,937,003,500.00	1,928,893,375.07	(8,110,124.93)	99.6
132	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	273,892,800.00	239,757,470.00	(34,135,330.00)	87.5
132001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	273,892,800.00	239,757,470.00	(34,135,330.00)	87.5
	Байгууллагын тоо	1	1	-	100.0
	Ажиллагсдын тоо	34	34	-	100.0
	Удирдах ажилтан	1	1	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	31	31	-	100.0
	Үйлчлэх ажилтан	2	2	-	100.0



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Малын удмын сангийн үндэсний төв нь Монгол малын үндэсний генийн санг үндэсний, бүс нутгийн төрөл зүйлийн төвшинд бүрдүүлэн сайжруулж, тэдгээрийг доройтох, мөхөх, устахаас хамгаалах, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, малын чанар, үйлдвэрийг сайжруулах, малын үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээнд биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, нутагшуулах, дэлгэрүүлэх, мал үржүүлгийн технологийн мэргэжилтэн сургаж бэлтгэх, үүлдэр, омгийн мал, түүний үржүүлгийн бүтээгдэхүүнд молекул, генетикийн шинжилгээ хийх зэрэг эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хууль, Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малын тоо толгойн албан татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна. Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Малын удмын сангийн үндэсний төв 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Малын удмын сангийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 336,667.5 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	935,082.3	981,071.8	45,989.5
Урьдчилгаа	70,860.0	70,860.0	-
Бараа материал	11,431,808.9	11,439,115.6	7,306.7
Үндсэн хөрөнгө	15,664,685.5	15,274,163.9	(390,521.6)
Нийт хөрөнгө	28,102,436.7	27,766,264.2	(336,172.5)
Өр төлбөр	117,946.0	121,151.1	3,205.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	27,984,490.7	27,645,113.2	(339,377.5)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	28,102,436.7	27,766,264.2	(336,172.5)

Авлагын дансны 981,071.8 мянган төгрөгийн үлдэгдлийн 517,790.3 мянган төгрөг нь байгууллагаас, 426,875.9 мянган төгрөг нь хувь хүмүүсээс, 36,405.6 мянган төгрөг нь ажилчин албан хаагчдаас авах авлага байна. Байгууллагаас авах авлагын 87 хувь буюу 450,000.0 мянган төгрөгийн, хувь хүнээс авах авлагын 12 хувь буюу 49,069.6 мянган төгрөгийн авлагууд нь шүүхийн шатанд хянагдаж байна.

Урьдчилгаа дансны 70,860,0 мянган төгрөгийн үлдэгдэл нь “Малын генийн санг хамгаалах, био технологийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх хөдөлгөөн өрнүүлэх тухай” хөтөлбөрийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгжид зохиомол хээлтүүлэг хийх ажлын урьдчилгаа төлбөр байна.

Бараа материал өмнөх оноос 7,306.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 408,168.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, ХХААХҮСайдын 2024 оны А/591 тоот тушаалаар малын чанар үүлдэрлэг байдлыг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор 262,037.5 мянган төгрөгийн өндөр ашиг шимт бухын гүн хөлдөөсөн үр, 76,800.0 мянган төгрөгийн өвс тэжээлийг өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн, 110,980.0 мянган төгрөгийн азот үйлдвэрлэсэн, 87,230.0 мянган төгрөгийн төл мал хүлээн авсан, 36,614.8 мянган төгрөгийн материал хүлээн авсан, 903,320.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан, 71,203.8 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн зэрэг ажил гүйлгээ бараа материалын өсөлтөд нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 15,274,163.9 мянган төгрөг болж 390,521.6 мянган төгрөгөөр буурчээ. Тайлант онд хандиваар 22,000.0 мянган төгрөгийн дурангийн аргаар зохиомол хээлтүүлэг хийх тоног төхөөрөмж, ХХААХҮЯ-аас 15,319.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, бараа материалын бүртгэлээс үндсэн хөрөнгөнд 47,142.8 мянган төгрөгийн хөрөнгүүдийг шилжүүлсэн байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар захиргаа, үйлдвэрлэлийн байрыг 263,831.8 мянган төгрөгөөр засвар хийж барилгын өртгийг нэмэгдүүлэн, 738,815.4 мянган төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 121,151.1 мянган төгрөг болж 3,205.1 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд ХХААХҮЯ-ны харьяа Хөдөө аж ахуйг дэмжих сангаас 92,383.5 мянган төгрөгийн үнэтэй Ловол трактор, өвс хаман боогч техник тоног төхөөрөмжийг зээлээр, үүний зээлийн хүү 6,684.1 мянган төгрөг, ажил гүйцэтгэх гэрээгээр төлбөрийг төлөөгөйтэй холбоотой байгууллагад төлөх өглөг 12,401.4 мянган төгрөг, хувь

хүмүүст төлөх өглөг 6,256.9 мянган төгрөг, НДШ-ийн өглөг 781.8 мянган төгрөг, ХХОАТ-ын өглөг 2,643.4 мянган төгрөг тус тус байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 27,645,113.2 мянган төгрөг болж, 339,377.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,431,765.5 мянган төгрөг, өөрийн орлогоос 401,592.8 мянган төгрөг, нийт 1,833,358.3 мянган төгрөгөөр тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн батлуулсан байна.

Тайлант онд батлагдсан төсвийг 377,538.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгон баталсан байна. Энэ нь Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотойгоор цалин, НДШ-ийн зардлыг 114,099.1 мянган төгрөг, Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний зохицуулах хорооны 2024 оны 48 тоот тогтоолоор үйлдвэр, аж ахуй нэгж байгууллагын цэвэр, бохир усны үнийн тарифыг нэмэгдүүлснээс байр ашиглалтын зардлыг 43,318.6 мянган төгрөг, албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор эд хогшил урсгал засварын зардлыг 24,977.7 мянган төгрөг, томилолт зочны зардлыг 47,571.1 мянган төгрөг, өвлийн улиралд байгууллагын уурын зуухыг хэвийн ажиллуулах зорилгоор бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлыг 52,853.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,210,896.3 мянган төгрөгийн санхүүжилтэд 1,937,003.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 273,892.8 мянган төгрөгийг өөрийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,937,003.5 мянган төгрөг, өөрийн орлогоос 239,757.7 мянган төгрөг төвлөрснөөс 2,168,650.8 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 8,110.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,168,650.8 мянган төгрөг буюу 98.1 хувьтай байгаа нь орон тоо дутуугаас цалин хөлс, нийгмийн даатгалын зардлыг 31,318.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөрийг 3,164.7 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 2,052.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	70801 хөтөлбөрийн хүрээнд	2,210,896.3	2,168,650.8	(42,245.5)	98.1
2	80101 үндсэн үйл ажиллагааны зардал	1,694,593.6	1,653,455.6	(41,138.0)	97.6
3	80102- Туслах үйл ажиллагааны зардал	108,531.7	108,220.9	(310.8)	99.7
4	80802 ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	3,390.0	2,670.0	(720.0)	78.8

5	82542 Монгол мал хөтөлбөр	404,381.0	404,304.3	(76.7)	99.9
---	---------------------------	-----------	-----------	--------	------

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 10,950.0 мянган төгрөг төвлөрснөөс бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөрт зарцуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Малын удмын сангийн үндэсний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хөрөнгө худалдан авалттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Гантулга гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Малын удмын сангийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийн зардлыг суурь үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны ажил гүйлгээний дийлэнх хувийг хөрөнгийн худалдан авалт эзэлж байгаа тул нийт хөрөнгийн дүн 27,788,589.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 277,885.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор цалин хөлс, бусад зардлыг батлагдсан төсвийн дагуу холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зарцуулсан байна.

Энэ хуулийн хүрээнд цэвэр, бохир усны төлбөрийг 16.4 хувь буюу 27,989.5 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 155,983.2 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулахтай холбоотой 4 мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байгаа тул Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулж байх, алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан ба нийт 2,175,054.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн бөгөөд ТШЗ-ийн 2024 оны 09 дүгээр сарын 2-ны өдөр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн биелэлтийг тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад 45 хувь хэрэгжсэн байна.

Хүснэгт 4 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
	Зөвлөмж	1	24,013.4	1	12,006.7
Албан шаардлага	3	2,151,041.3	3	860,416.5	40
Нийт дүн	4	2,175,054.7	4	872,423.2	45

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах талаар дараах ажлуудыг зохион байгуулж ажилласан байна. Үүнд:

- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 241 нэр төрлийн 936,850.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шийдвэрлүүлэхээр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт холбогдох материалыг бүрдүүлэн явуулсан байна. Үндсэн хөрөнгөтэй холбоотой мэдээлэл дутуугаас хугацаа хойшлогдсон байна.

- Авлага, өглөгийн барагдуулах ажлын комиссыг байгуулж, холбогдох иргэн, аж ахуй нэгж байгууллагатай холбогдон харилцагч байгууллагын 450,000.0 мянган төгрөг, иргэний 49,069.6 мянган төгрөгийн авлагыг шийдвэрлүүлэхээр шүүхийн байгууллагад өгсөн байна. Зарим харилцагч иргэний хаягын мэдээлэл тодорхойгүйгээс материалыг бүрдүүлэн дээд шатны байгууллагад танилцуулсан байна. Бусад зөрчлийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 211,977.1 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлж аудитын явцад залруулав. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайланд 211,482.1 мянган төгрөгийн орлогыг дутуу илэрхийлсэн нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн тодруулга”, “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн тайланд дүнг нэмж залруулав,
2. Ерөнхий журналд орлогын 494.9 мянган төгрөгийн гүйлгээг хасах дүнтэй илэрхийлсэн нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн тодруулга”, НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 8 дугаар зүйлийн 8.4, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсэг, “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Иж бүрэн байх” зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байгаа тул санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлогын дансанд зөв тусгаж залруулав.

Мөн аудитаар нийт 757,031.9 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 460,255.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж, 293,148.5 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 3,627.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоолоо.

5.1 Төлбөрийн акт

1. Цалингийн зардал

Илрүүлэлт

Тайлант онд байгууллагын 3 албан хаагчийн сахилгын шийтгэлийн хугацаа дуусаагүй байхад ажлын үр дүнгийн урамшуулалд 1,090.5 мянган төгрөг тооцож олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоол 3 дугаар хавсралтын 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй”, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 8.2.1-т “Сахилгын шийтгэлийн хугацаа дуусаагүй ажилтнаас бусад ажилтан ажлын байран дээр мэргэжлийн үр чадвар гарган үр өгөөжтэй ажиллаж, байгууллагын орлогыг тодорхой хувиар өсгөсөн бол ажил олгогчийн шийдвэрээр урамшуулал олгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

2. Цалингийн зардал

Илрүүлэлт

Тайлант онд байгууллагын 2 албан хаагчид биеэр эдлээгүй ээлжийн амралтын цалинг 2,537.2 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.2-т “Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Худалдан авах ажиллагаа

Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй нийт 24,950.0 мянган төгрөгийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны бодлого, зорилт,

¹ Мэдээллийг тусгахгүй орхиадуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

салбарын цаг үеийн мэдээллийг олон нийтэд сурталчлах ажлыг 6 хувааж, шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг хориглоно”, 10.5-т “Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно”, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоол “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай”-ын хавсралтад заасантай тус тус нийцэхгүй байгаа тул зөрчил арилгах албан шаардлага хүргүүлээ.

2. Авлагын данс

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайланд бүртгэсэн 261,941.5 мянган төгрөгийн авлагыг байгууллага, хувь хүмүүстэй тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул зөрчил арилгах албан шаардлага хүргүүлээ.

3. Өглөгийн данс

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайланд бүртгэсэн 6,256.9 мянган төгрөгийн өглөгийг хувь хүмүүстэй тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул зөрчил арилгах албан шаардлага хүргүүлээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд 458,163.8 мянган төгрөгийн үйлдвэр, захиргааны байрын засвар, худалдан авалтын үр дүнг цахим хуудсанд мэдээлээгүй байна. Энэ нь Төрийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.5-т “тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүр цахим системд нийтлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байх

2. Цалингийн зардал

Илрүүлэлт:

Аюулгүй байдлын шалгалтад хамрагдаагүй албан хаагчийг Эрх бүхий албан тушаалд томилж 2,091.9 мянган төгрөгийн цалин олгосон нь Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт 1.2 "Нууц хамгаалах ажилтнаар тагнуулын байгууллагын Аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж тэнцсэн хүнийг тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр томилно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Аюулгүй байдлын шалгалтад хамрагдсан албан хаагчийг байгууллагын нууцын албан тушаалд томилж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байх

Дээрх зөвлөмж болон тайлангийн 4.4.1 дэх хэсэгт дурдсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайланд орлогыг дутуу илэрхийлсэн	1	211,482.1	-	-	-	-	1	211,482.1	-	-	-	-
Ерөнхий журналд орлогын гүйлгээг хасах дүнтэй илэрхийлсэн	1	494.9	-	-	-	-	1	494.9	-	-	-	-
Дүн	2	211,977.1	-	-	-	-	2	211,977.1	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан шаардлагын тэмдэгт	Тоо	Дүн
Сахилгын шийтгэлийн хугацаа дуусаагүй байхад үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон	1	1,090.5	1	1,090.5	-	-	-	-	-	-	-	-
Ээлжийн амралт биеэр эдлээгүй ажилтан, албан хаагчид амралтын цалинг илүү тооцож олгосон	1	2,537.2	1	2,537.2	-	-	-	-	-	-	-	-
Аюулгүй байдлын шалгалтад хамрагдаагүй албан хаагчийг ЭБАТ-д томилж цалин олгосон	1	2,091.9	-	-	-	-	1	2,091.9	-	-	-	-
Худалдан авах ажиллагааны үр дүнг цахим сайтад байршуулаагүй	1	458,163.8	-	-	-	-	1	458,163.8	-	-	-	-
Нэг төрлийн ажил үйлчилгээг жижиглэн шууд гэрээгээр гүйцэтгэсэн	1	24,950.0	-	-	1	24,950.0	-	-	-	-	-	-
Тайлант оны эцэст авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	261,941.5	-	-	1	261,941.5	-	-	-	-	-	-
Тайлант оны эцэст өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	6,256.9	-	-	1	6,256.9	-	-	-	-	-	-
Дүн	7	757,031.9	2	3,627.7	3	293,148.4	2	460,255.7	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хөрөнгө зарцуулахтай холбоотой 4 тушаал шийдвэрийг оруулаагүй байна.	1	155,983.2	-	-	-	-	1	155,983.2
Дүн	1	155,983.2	-	-	-	-	1	155,983.2